

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ.
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

*/Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын
15-ны өдрийн 89-р тогтоолоор батлагдсан
журмын 5-р хавсралтын дагуу бэлтгэв/*

| № | Хөтөлбөр/төслийн агуулга | Гүйцэтгэл |
|----|---|---|
| 1. | Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: Уялдаа холбоо бүхий дэд/төсөл хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана.) | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ТА-9137 MON төсөл |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаа |
| 3. | Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа | Зам, тээврийн хөгжлийн яам Төсөл 2017 оны 4-р сараас 2018 оны 9-р сар хүртэл үргэлжлэнэ. |
| 4. | Төсөл, хөтөлбөрийн зорилтууд | <p>I. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын “Цагаан ном” гаргана.</p> <p>II. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хянана.</p> <p>III. Замын хөдөлгөөний менежментийн чадавх, хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэг, боловсрол, ойлголтыг сайжруулж, энэ чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын үр нөлөө, уялдааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>IV. Осол, хэргийн мэдээллийн сангийн менежментийн системийг боловсруулан, осол зөрчлийн талаарх тоон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулна.</p> <p>V. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох төрөл бүрийн гарын авлага, сургалтын материал бэлтгэнэ.</p> <p>Төслийг хэрэгжүүлэх арга зүй нь НҮБ-аас тунхагласан “Хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах Арван жилийн үйл ажиллагааны удирдамжийн зарчим”-уудад суурилах бөгөөд түүний таван тулгуур бүлэг арга хэмжээний хүрээнд хийгдэнэ.</p> <p>Үндсэн зарчим нь үндэсний болон орон нутгийн хэмжээний асуудлыг хамруулах арга зүйг ашиглан, гол оролцогч талуудтай нягт хамтран ажиллаж, Монголын өвөрмөц онцлогийг тусган ажиллах явдал юм.</p> <p>Энэхүү таван тулгуур бүлэг хүчин зүйлд:</p> <p>1/ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын менежмент</p> <p>2/ Аюулгүй зам</p> <p>3/ Аюулгүй тээврийн хэрэгсэл</p> <p>4/ Аюулгүй зорчигчид</p> <p>5/ Ослын дараах эмнэлгийн үйлчилгээ зэрэг ордог.</p> |

| | | | | | | | | |
|----|---|--|--|-----------|--|--|------|--|
| | | | Эдгээр тулгуур хүчин зүйл нь нь уг төслийн үйл ажиллагааны чиглэл, мөн холбогдох үр дүнгийн баримт бичгүүдийн бүтцийг тодорхойлно. | | | | | |
| 5. | Зардал | Төсөв (Нийт шаардагдах зардал) | 1 сая.ам доллар | | | | | |
| | | Үүнд: | Төсөв (он) | Гүйцэтгэл | | | Хувь | |
| | | Багц 1 Багц 2 | | | | | | |
| 6. | Төсөл, хөтөлбөрийн зорилт | Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ. | | | | | | |
| | 1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын “Цагаан ном” гаргана. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын “Цагаан ном”-ыг боловсруулж ЗТХЯ-нд хүлээлгэн өгсөн. | | | | | | |
| | 2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратеги, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хянана. | Төслийн баг замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний стратеги болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хянаж зохих өөрчлөлтийг хийж, ЗТХЯ-нд хүлээлгэн өгсөн. | | | | | | |
| | 3. Замын хөдөлгөөний менежментийн чадавх, хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх мэдлэг, боловсрол, ойлголтыг сайжруулж, энэ чиглэлээр зохион байгуулж ажлын үр нөлөө, уялдааг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. | <p>“Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил” сэдэвт хэд хэдэн семинарыг оролцогч талуудыг байлцуулан зохион байгуулсан.</p> <p>Туршилтын ажлыг “суудлын бүс/хүүхдийн суудал”-ын хэрэглээ сэдвээр Чингэлтэй, Хайлаастын зам дээр зохион байгуулсан.</p> <p>Холбогдох байгууллагуудын албан хаагчдыг хамарсан дараах сургалт болон семинарыг Улаанбаатар хотод болон орон нутагт зохион байгуулсан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил сэдэвт семинар 2. Мэргэшсэн жолооч нарт олгох сургалт 3. Осол гэмтэлд өртсөн хүмүүст яаралтай тусламж үзүүлэх, чадавхийг дээшлүүлэх “сургагч багш” бэлтгэх сургалт 4. Замын цагдаагийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх сургалт 5. Зам, тээврийн ослын бүртгэл, мэдээллийн системийн сургалт 6. Замын хөдөлгөөний аюулгүй байдал болон Зам, тээврийн ослын бүртгэл, мэдээллийн системийн сургалт 7. Авто замд хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх болон осол зөрчлийг шинжлэн шалгах тухай сургалт | | | | | | |
| | 4. Осол, хэргийн мэдээллийн сангийн менежментийн системийг боловсруулан, осол зөрчлийн талаарх тоон мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулна. | Зам тээврийн ослын мэдээллийг бүртгэх систем болон түүний мэдээллийн сангийн программ хангамжийг хөгжүүлж, тоног төхөөрөмжийн хамт тээврийн цагдаагийн албанд хүлээлгэн өгсөн. | | | | | | |

| | | | | | | | | |
|-----|--|--|--------------|----------|----------|----------|----------|----------|
| | 5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаар мэдлэг олгох төрөл бүрийн гарын авлага, сургалтын материал бэлтгэнэ. | Дээр дурдсан нэр бүхий сургалтын материалуудыг боловсруулж, хамрагдсан албан хаагчдад болон холбогдох байгууллагуудад нь хүлээлгэн өгсөн. | | | | | | |
| | 7. Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | Төслийн осол, аваарыг бүртгэх програмын Source code; эх хувийг олгох чиглэлээр Замын цагдаагийнхантай оновчтой шийдэлд хүрэхээр ажиллаж байна. | | | | | | |
| | 8. Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ | Төсөл хэрэгжүүлэгч талуудын хоорондын хамтын ажиллагаа сайн байна. | | | | | | |
| 9. | Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ) | Биелэлт дундаж | Зорилтын тоо | Зорилт 1 | Зорилт 2 | Зорилт 3 | Зорилт 4 | Зорилт 5 |
| | | 100% | | 100% | 100% | 100% | 100% | 100% |
| 10. | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ) | Нэгдсэн ... % | | | | | | |

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ.
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

| № | Хөтөлбөр/төслийн агуулга | | Гүйцэтгэл | | | | |
|----|---|--------------------------------|--|-----------|----------|----------|--|
| 1. | Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: Уялдаа холбоо бүхий дэд/төсөл хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана.) | | Монгол Улсад тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ТА 9131 MON төсөл | | | | |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | | Азийн хөгжлийн банкны техникийн туслалцаа | | | | |
| 3. | Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа | | Зам, тээврийн хөгжлийн яам Төсөл 2017 оны 4-р сараас 2018 оны 7-р сар хүртэл үргэлжлэнэ. | | | | |
| 4. | Төсөл, хөтөлбөрийн зорилтууд | | I. Үндэсний тээврийн ухаалаг системийн бодлого болон стратеги төлөвлөгөө боловсруулах. II. Тээврийн ухаалаг системийн оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх. III. Мэдлэгт суурилсан бүтээгдэхүүнийг түгээх. | | | | |
| 5. | Зардал | Төсөв (Нийт шаардагдах зардал) | 500 мян.ам доллар | | | | |
| | | Үүнд: | Төсөв (он) | Гүйцэтгэл | | Хувь | |
| | | Багц 1 | | | | | |
| | | Багц 2 | | | | | |
| 6. | Төсөл, хөтөлбөрийн зорилт | | Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ. | | | | |
| | 1. Үндэсний тээврийн ухаалаг системийн бодлого болон стратеги төлөвлөгөө боловсруулах. | | Монгол улсын хэрэгцээ, шаардлага, стандартад нийцсэн Үндэсний хэмжээний тээврийн ухаалаг системийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан эцсийн тайлангийн хамт ЗТХЯ болон бусад холбогдох байгууллагуудад хүлээлгэж өгсөн. | | | | |
| | 2. Тээврийн ухаалаг системийн оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх. | | Төслийн хүрээнд 2 сургалтыг зохион байгуулсан. Үүнд: 1. Тээврийн ухаалаг системийн ерөнхий ойлголт 2. Тээврийн ухаалаг систем ба Монгол улс; Солонгос улсын туршлага | | | | |
| | 3. Мэдлэгт суурилсан бүтээгдэхүүнийг түгээх. | | Төслийн баг Монгол улсад нутагшуулж болохуйц гадаад улс орнуудын ТУС-ийн туршлагыг судалж, мэдлэгт суурилсан бүтээгдэхүүнийг боловсуулсан. | | | | |
| 7. | Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | | Төслийн эцсийн тайланг ЗТХЯ-д 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор ирүүлсэн байх. | | | | |
| 8. | Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ | | Төсөл хэрэгжүүлэгч талуудын хоорондын хамтын ажиллагаа сайн байна. | | | | |
| 9. | Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, | Биелэлт дундаж | Зорилтын тоо | Зорилт 1 | Зорилт 2 | Зорилт 3 | |
| | | 100% | | 100% | 100% | 100% | |



| | | | | | | |
|-----|---|-----------------------------------|------------------|--|--|--|
| | дүгнэлт (өөрийн үнэлгээ) | | | | | |
| 10. | Төсөл, хэрэгжилтийн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ) | хөтөлбөрийн нэгдсэн үнэлгээ | Нэгдсэн ... % | | | |

Тайлбар:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байнууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын Хавсралт 5